



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

“Найдвартай хөгжил” ХЗХ-ны хадгаламж,
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.7.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Найдвартай хөгжил” ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Хадгаламж, зээлийн хоршоог татан буулгаж, хадгаламж, зээлийн үлдэгдэл, төлбөр тооцоог барагдуулахыг “Найдвартай хөгжил” ХЗХ /М.Жамъяаншарав/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000090